

2025.02.06

№ 25/02

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

*Компанийн Бизнес төлөвлөгөө,
2025 оны төсөв батлах тухай*

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрэм, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дараах шийдвэрүүдийг 2024 оны 4-р улирлын ТУЗ-ийн ээлжит хурлын тэмдэглэлд дурдсан огнооноос эхлэн хүчин төгөлдөрт тооцохоор:

ҮНДЭСЛЭХ НЬ:

1. ТУЗ-ийн ээлжит хурлыг дээр дурдсан огноонд хэлэлцээнийг **ТЭМДЭГЛЭН**;
2. ТУЗ нь энэхүү Тогтоолд дурдсан асуудлыг тогтоох бүрэн эрхтэй болохыг **ТЭМДЭГЛЭН**;
3. ТУЗ-ийн дарга нь энэхүү тогтоолд ТУЗ-ийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах бүрэн эрхтэй болохыг **ТЭМДЭГЛЭЖ**;

ТОГТООХ НЬ:

1. Компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг энэхүү тогтоолын Хавсралт 1-ээр **БАТАЛСУГАЙ**.
2. Компанийн 2025 оны нэгдсэн болон бие даасан төсвийг энэ тогтоолын Хавсралт 2 ба Хавсралт 3-аар тус тус **БАТАЛСУГАЙ**.
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, компанийн өдөр тутмын үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу удирдан зохион байгуулж, мөрдөж ажиллахыг Санхүү эрхэлсэн захирал Г.Билгүүн, Гүйцэтгэх захирал Б.Золбоод тус тус үүрэг **БОЛГОСУГАЙ**.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ГАНХУЯГ

2025.02.06

№ 25/03

Улаанбаатар хот

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Компанийн тухай хуулийн 76-р зүйл, Ард Санхүүгийн Нэгдэл ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 8.1.3 дахь хэсэг, Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн дараах шийдвэрүүдийг 2024 оны 4-р улирлын ТУЗ-ийн ээлжит хурлын тэмдэглэлд дурдсан огнооноос эхлэн хүчин төгөлдөрт тооцохоор:

ҮНДЭСЛЭХ НЬ:

1. ТУЗ-ийн ээлжит хурлыг дээр дурдсан огноонд хэлэлцсэнийг **ТЭМДЭГЛЭН**;
2. ТУЗ нь энэхүү Тогтоолд дурдсан асуудлыг тогтоох бүрэн эрхтэй болохыг **ТЭМДЭГЛЭН**;
3. ТУЗ-ийн дарга нь энэхүү тогтоолд ТУЗ-ийн нэрийн өмнөөс гарын үсэг зурах бүрэн эрхтэй болохыг **ТЭМДЭГЛЭН**;
4. ТУЗ-ийн дэргэдэх хороодоос хэд хэдэн зөвлөмж, шийдвэр гарсныг тус тус **ТЭМДЭГЛЭЖ**;

ТОГТООХ НЬ:

1. Дараах этгээдийг Ард Менежмент ҮЦК ХХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээр 2025 оны 2 сарын 6-наас эхлэн **ТОМИЛСУГАЙ**:
 1. Чулууны Ганхуяг;
 2. Батбилэгийн Золбоо;
 3. Мөнхчулууны Санчир.
2. Ард Реалти ХХК-ийн гүйцэтгэх захирал Ж.Алтангүний-г чөлөөлж, Н.Ерөөлт-Учралт-г Гүйцэтгэх захирлаар **ТОМИЛСУГАЙ**;
3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, Ард Менежмент ҮЦК ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд компанийг төлөөлж оролцох эрхийг компанийн Гүйцэтгэх захирал Б.Золбоод **ОЛГОСУГАЙ**.

ТУЗ-ИЙН ДАРГА



Ч.ГАНХУЯГ